



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНД, СПОРТЫН САЙДЫН ТУШААЛ

2015 оны 8 сарын 26 өдөр

Дугаар 329

Улаанбаатар хот

Заавар, журам батлах тухай


Монгол улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1, Эрүүл мэндийн тухай хуулийн 8 дугаар зүйлийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Хөнгөвчлөх тусламж, үйлчилгээ үзүүлэх журмыг нэгдүгээр, Хөнгөвчлөх тусламж, үйлчилгээ үзүүлэх зааврыг хоёрдугаар хавсралтаар баталсугай.

2. Тушаалыг мөрдөж ажиллахыг бүх шатны эрүүл мэндийн байгууллагын дарга, захирал нарт даалгасугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж, ажиллахыг Эрүүл мэндийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар /О.Баяр/-т, Хяналт, шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар /Э.Оюунсүрэн/-т тус тус даалгасугай.

САЙД



Г. ШИЙЛЭГДАМБА

D:\barimt\tushaal

081166

Эрүүл мэнд, спортын сайдын
2015 оны 2 сарын 26 өдрийн
329 дугаар тушаалын 1 дүгээр
хавсралт

ХӨНГӨВЧЛӨХ ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1. Энэхүү журмын зорилго нь хөнгөвчлөх тусламж үйлчилгээ шаардлагатай иргэнийг (цаашид өвчтөн гэх) эрүүл мэндийн байгууллага хооронд шилжүүлэх, хөнгөвчлөх тусламж үйлчилгээг нэгдсэн удирдлагаар хангах, бүртгэх, мэдээлэх, тайлагнах, хянах асуудлыг зохицуулахад оршино.
2. Аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газар нь харьяалах нутаг, дэвсгэрийн эрүүл мэндийн байгууллага (өмчийн хэлбэр харгалзахгүйгээр) хооронд өвчтөн шилжүүлэх, мөн хүлээн авах үйл ажиллагаанд хяналт тавьж, мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах үүрэгтэй.
3. Тусгай зөвшөөрөлтэй хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллага нь хөнгөвчлөх тусламж, үйлчилгээ үзүүлэхдээ өвчтөнг энэхүү журмын дагуу шилжүүлэх болон хүлээн авч, харилцан ажиллах үүрэгтэй.
4. Эрүүл мэндийн байгууллага хооронд өвчтөн шилжүүлэх, хүлээн авах талаар энэ журмаар зохицуулагдаж байгаа үйл ажиллагааг зөрчсөний улмаас өвчтөний эрүүл мэнд, амь насанд хохирол учирсан бол холбогдох хуульд заасан хариуцлагыг буруутай байгууллага, албан тушаалтан хүлээнэ.
5. Эрүүл мэндийн байгууллага нь хөнгөвчлөх тусламж, үйлчилгээ үзүүлсэн иргэдийн бүртгэлийг АМ26а, АМ26б маягтын дагуу гаргаж, сар, улирал, жилээр нэгтгэн холбогдох журмын дагуу дараагийн шатны байгууллагад мэдээлнэ.
6. Эрүүл мэндийн байгууллагууд нь өвчтөнд хөнгөвчлөх тусламж, үйлчилгээ үзүүлэхдээ батлагдсан стандарт, эмчилгээний заавар, удирдамжуудыг мөрдлөг болгон ажиллана.

Хоёр. Эрүүл мэндийн байгууллагын үүрэг.

1. Төв эмнэлэг, БОЭТ, тусгай мэргэжлийн төв нь тухайн мэргэжлийн чиглэлээр хөнгөвчлөх тусламж, үйлчилгээг үндэсний хэмжээнд зохицуулах, мэргэжил арга зүйгээр хангах, мэргэжилтнүүдийг сургах, чадавхийг бэхжүүлэх үндсэн чиг үүрэгтэй ажиллана.
2. Төв эмнэлэг, БОЭТ, тусгай мэргэжлийн төв нь эрхтэн системийн өвчлөл төгсгөлийн шатанд орсон, эдгэрүүлэх эмчилгээ үр дүнгүй, эсвэл эмчилгээний эрсдэл ихтэй, амь насанд нь аюултай болсон өвчтөнийг хөнгөвчлөх тусламж, үйлчилгээнд шилжүүлэх тухай шийдвэрийг эхэлж гаргах ба хөнгөвчлөх тусламж, үйлчилгээг цаашид хэрхэн үзүүлэх талаар өвчтөн, түүний гэр бүлийнхэнд тайлбарлаж, зөвшөөрөл авсны дараа аймаг, дүүрэг, өрх, сумын эрүүл мэндийн төвд шилжүүлнэ.

3. Аймаг, дүүргийн эрүүл мэндийн төвд амбулаторийн, гэрийн эргэлтийн ба хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээг өрх, сумын эрүүл мэндийн төв, төв эмнэлэг, төрөлжсөн мэргэжлийн төв, БОЭТ-өөс илгээсэн үйлчлүүлэгчид хөнгөвчлөх тусламж, үйлчилгээг үзүүлнэ.
 - 3.1 Аймаг, дүүргийн нэгдсэн эмнэлэг нь 5 ор бүхий хэвтүүлэн эмчлэх тасагтай байна.
 - 3.2 Аймаг, дүүргийн нэгдсэн эмнэлгийн 4-6 оронд нэг эмч, 1-3 оронд нэг сувилагч ажиллана.
 - 3.3 Хөнгөвчлөх тусламж, үйлчилгээнд мэргэшсэн эмч, сувилагч ажиллах ба олон мэргэжлийн багийн тусламж, үйлчилгээг үзүүлэх шаардлагатай тохиолдолд нэмэлтээр зохицуулна.
 - 3.4 Аймаг, дүүргийн нэгдсэн эмнэлэг нь хөнгөвчлөх тусламж, үйлчилгээ, үзлэг, шинжилгээ, бүртгэл, мэдээллийг хийж, аймаг, дүүргийн хэмжээнд хөнгөвчлөх эмчилгээ шаардлагатай иргэдийн тоо, мэдээ, мэдээлэл, статистикийг энэ журмын 1,5-д заасны дагуу нэгтгэн гаргана.
4. Өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төв нь үйлчлэх хүрээний хүн амын хөнгөвчлөх тусламж, үйлчилгээний заалт бүхий иргэдэд тусламж, үйлчилгээ үзүүлэхээс гадна үндсэн ба төрөлжсөн мэргэжлийн байгууллагуудтай байнга эргэх холбоотой ажиллана.
 - 4.1 Тусламж, үйлчилгээний тасралтгүй байдал, хяналт, бүртгэлийг хийж эргэн мэдээлэх үүрэг хүлээнэ.
 - 4.2 Өвдөлт намдаах, эм бэлдмэлийг журмын дагуу жороор олгох, өвдөлт намдаах, шинж тэмдгийн эмчилгээ, сувилгааг батлагдсан стандарт, журмын дагуу үзүүлнэ.
 - 4.3 Иргэний эрүүл мэндийн дэвтэрт үзүүлсэн тусламж, үйлчилгээ, зөвлөгөөг нарийвчлан тэмдэглэнэ.
 - 4.4 Гэрийн эргэлт хийх, гэрээр зөвлөгөө өгөх, үйлчлүүлэгчийн ар гэр, асран хамгаалагчид хөнгөвчлөх тусламж үйлчилгээг гэрээр үзүүлэх, сургалт зохион байгуулах арга хэмжээг холбогдох хууль, эрхийн хүрээнд хэрэгжүүлнэ.
5. Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй, магадлан итгэмжлэгдсэн, даатгалын байгууллагатай гэрээ бүхий хувийн хэвшлийн хөнгөвчлөх тусламж үйлчилгээ үзүүлэх төрөлжсөн байгууллага нь санхүүжилтийн эх үүсвэрээс үл хамааран энэхүү журам болон хөнгөвчлөх тусламж, үйлчилгээнд холбогдох хууль эрхийг мөрдлөг болгон ажиллана.
 - 5.1 Хөнгөвчлөх тусламж үйлчилгээ үзүүлэх хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллага нь хэвтүүлэн эмчлэх ортой бол 4-6 оронд нэг эмч, 1-3 оронд 1 сувилагчтай байх ба оргүй бол гэрээр, өдрөөр, амбулаториор тусламж үйлчилгээг үзүүлнэ.
 - 5.2 Хөнгөвчлөх тусламж, үйлчилгээ үзүүлсэн хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллага нь нийт үйлчилгээ үзүүлсэн иргэдийн бүртгэлийг, оношийн хамт гаргаж аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газарт хагас, бүтэн жилээр хүргүүлнэ.
 - 5.3 Хөнгөвчлөх эмчилгээ, асаргаа, сувилгаа, тусламж, үйлчилгээг зөвхөн эрх бүхий мэргэжлийн эмчийн үзлэг, хяналт заалтаар стандарт, журамд заасан хүрээнд үзүүлнэ.


Гурав. Эрүүл мэндийн байгууллага хооронд хөнгөвчлөх тусламж, үйлчилгээ шаардлагатай өвчтөн шилжүүлэх, хүлээн авах

1. Өвчтөнийг эрүүл мэндийн байгууллага хооронд шилжүүлэхдээ эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын баталсан хөнгөвчлөх эмчилгээ, үйлчилгээний оношийн бүлгийг баримтална.
2. Шилжүүлэгч эрүүл мэндийн байгууллага, өвчтөнийг дараагийн шатны эрүүл мэндийн байгууллагад илгээхдээ үндсэн онош, бодит үзлэг, клиникийн шинж, явц, үе шат, дагалдах өвчин, стационар, амбулаторид хийлгэсэн шинжилгээ, нарийн мэргэжлийн эмч нарын гаргасан дүгнэлт зэрэг үндсэн баримтыг амбулаторийн карт болон илгээх картанд тэмдэглэж, хувийг хавсаргана.
3. Эрүүл мэндийн байгууллагаас олгосон илгээх карт, шимтгэл төлж, тэмдэглэл хийлгэж баталгаажуулсан эрүүл мэндийн даатгалын дэвтрийг үндэслэн өвчтөнийг бүртгэн өвчний карт, хэвтүүлэн эмчлэх байгууллагад бол өвчний түүх бичиж хүлээж авна.
4. Хүлээн авагч байгууллага нь тухайн эмчилгээ, сувилгааны хугацаа дуусахад эмчилгээ, сувилгааны хүрсэн үр дүнг тооцож, ажил, амралт, хооллох дэглэм, оршин суугаа газартаа хэрхэн бүртгүүлэх, хяналтад орох, үргэлжлүүлэн эмнэлэг болон гэрээр хийгдэх эмчилгээ, сувилгааны талаар мэргэжлийн зөвлөгөөг иргэний эрүүл мэндийн дэвтэрт бичиж тэмдэглэх буюу өвчтөн түүний ар гэрт зөвлөгөө өгч, гаргах буюу шилжүүлнэ.

Дөрөв. Хяналт, үнэлгээ

1. Аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газар нь харьяалах нутаг дэвсгэрийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний байгууллага хооронд хөнгөвчлөх тусламж, үйлчилгээ шаардлагатай өвчтөнийг шилжүүлэх, хүлээн авах ажиллагаанд хяналт тавьж, үйл ажиллагааг уялдуулан зохион байгуулна.
2. Аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газар нь хөнгөвчлөх тусламж, үйлчилгээ үзүүлсэн болон эрүүл мэндийн байгууллага хооронд шилжүүлсэн, хүлээн авсан өвчтөний талаархи мэдээллийн нэгдсэн санг харьяалах нутаг дэвсгэрийн хүрээнд гаргаж, хагас бүтэн жилийн дүнг Эрүүл мэндийн хөгжлийн төвд ирүүлнэ.
3. Хөнгөвчлөх тусламж, үйлчилгээ үзүүлж буй эрүүл мэндийн байгууллага нь Монгол улсын үндэсний стандарт, Хөнгөвчлөх тусламж, үйлчилгээ /MNS 5455-1: 2005/; Монгол улсын үндэсний стандарт, Хөнгөвчлөх тусламж, үйлчилгээ үзүүлэх байгууллагын бүтэц, үйл ажиллагаа /MNS 5455-2: 2005/ болон энэхүү тушаал, бусад холбогдох тушаал, дүрэм, зааврын хэрэгжилтийг хангаж ажиллана.
4. Хөнгөвчлөх тусламж, үйлчилгээний чанарыг тогтмол сайжруулах хяналтын тогтолцоо нь эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, мэргэжлийн хяналт, хөндлөнгийн хяналтын байгууллага, тусламж, үйлчилгээ үзүүлэгч байгууллагын өөрийн үнэлгээнээс бүрдэнэ.

Эрүүл мэнд, спортын сайдын
2015 оны 8 сарын 26 өдрийн
329 дугаар тушаалын 2 дугаар
хавсралт



ХӨНГӨВЧЛӨХ ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ ЗААВАР

Нэг. Нийтлэг зүйлс

1. Хөнгөвчлөх тусламж, үйлчилгээг үзүүлэх заалт, баримтлах зарчим, үйл ажиллагааг энэхүү журмаар зохицуулна.
2. Зааврын нийтлэг зорилго нь хөнгөвчлөх тусламж, үйлчилгээний чанар сайжруулах, хөнгөвчлөх тусламж, үйлчилгээ шаардлагатайг тогтоох, үйлчлүүлэгч (цаашид өвчтөн гэх) болон түүний ар гэрийнхэн, асран хамгаалагчийн сэтгэл ханамжийг дээшлүүлэхэд оршино.
3. Хөнгөвчлөх тусламж, үйлчилгээ гэдэг нь архаг, илаарших боломжгүй, хүнд өвчтэй, амьдралын төгсгөлийн шатанд орсон өвчтөний өвдөлт, бие, сэтгэлийн зовиур шаналгааг хөнгөвчлөхөд чиглэсэн асаргаа, сувилгаа, эмчилгээ, үйлчилгээний цогц болно.
4. Даатгалаас санхүүжилт авах байгууллага нь үйлчилгээ үзүүлсэн иргэдийг /AM26а, AM26б/ бүртгэж, үзүүлсэн тусламж үйлчилгээг иргэний эрүүл мэндийн дэвтэрт нь тэмдэглэх ба энэхүү бичиг, баримт нь байгууллагын болон иргэний эрүүл мэндийн даатгалаас санхүүжилт авах үндсэн баримт болно.

Хоёр. Хөнгөвчлөх тусламж, үйлчилгээ үзүүлэхэд баримтлах зарчим

1. **Өвчтөний (хүүхэд насанд хүрэгч) өвөрмөц сэтгэл зүйд тулгуурласан тусламж, үйлчилгээний зарчим:** Хүүхэд, насанд хүрэгч, өндөр настан зэрэг бүх насны, архаг болон амь насанд нь аюул тулгарсан өвчин эмгэгтэй хүмүүсийн бие бялдар, нас, сэтгэл зүйд тулгуурласан тусламж, үйлчилгээг үзүүлнэ.
2. **Өвчтөн ба гэр бүл төвтэй тусламж, үйлчилгээний зарчим:** Өвчтөн, түүний гэр бүлийн эрхийг нь хамгаалсан, хүндэтгэсэн тусламж, үйлчилгээг үзүүлнэ. Насанд хүрээгүй, эсвэл шийдвэр гаргах чадваргүй өвчтөний асуудлаар гаргах аливаа шийдвэрт өөрийнх нь саналыг заавал харгалзан тусгана.
3. **Хөнгөвчлөх тусламж, үйлчилгээний тасралтгүй байдлыг хангах зарчим:** Хөнгөвчлөх тусламж, үйлчилгээ нь өвчтөний амь насанд нь аюултай, эсвэл эрүүл мэндийн хувьд эдгэшгүй, хүнд нөхцөлд орсныг нь оношилсон цагаас эхлэн нас барах, мөн түүнчлэн гэр бүлийн гишүүдийн уй гашууг хуваалцах хүртэл тасралтгүй үргэлжлэх үйл ажиллагаа болно.
4. **Тусламж, үйлчилгээний цогц байдлын зарчим:** Хөнгөвчлөх тусламж, үйлчилгээ нь өвчтөний эрүүл мэндийн байдлыг бие бялдар, сэтгэл зүй, нийгэм, оюун санааны хувьд нь тодорхойлж, үнэлгээ өгөх, оношлох, төлөвлөх, хэрэгжүүлэх, хяналт тавих үйл ажиллагааны бүрдэл болно.

5. **Салбар хоорондын хамтын ажиллагааны зарчим:** Хөнгөвчлөх тусламж, үйлчилгээ нь холбогдох бүх шатны байгууллага, олон мэргэжлийн багийн хамтын ажиллагаатай байна.
6. **Зовлонг нимгэлэх зарчим:** Хөнгөвчлөх тусламж, үйлчилгээний онцлог нь өвчтөний зовиур, шаналгаа, зовлонг хуваалцахад оршино.
7. **Харилцааны ур чадварын зарчим:** Хөнгөвчлөх тусламж, үйлчилгээнд үр дүнтэй харилцааны ур чадвар гол үүрэгтэй. Мэдээлэл солилцох, идэвхитэй сонсогч байх, хэрэгцээг тодорхойлж шийдвэр гаргах, өвчтөн түүний гэр бүлийн гишүүдийн идэвхитэй хамтрагч байх шаардлагатай.
8. **Нас барж буй үед үзүүлэх тусламж болон уй гашууг хуваалцах зарчим:** Хөнгөвчлөх тусламж, үйлчилгээг үзүүлэгч эрүүл мэндийн мэргэжилтэн нь өвчтөний биеийн байдлыг бодитойгоор үнэлэх ур чадвартай, зайлшгүй ирэх мөчийг урьдчилан таамаглаж, гэр бүлийн гишүүдэд үнэн мэдээллийг хүргэх, уй гашууг нь хуваалцах, зөвлөх үүрэгтэй.
9. **Тусламж, үйлчилгээний удирдлагын тасралтгүй байдлыг хангах зарчим:** Тусламж, үйлчилгээ үзүүлэгч байгууллагууд нь нэгдсэн удирдлага, зохион байгуулалтаар хангагдсан, тусламж үйлчилгээг үзүүлэх арга аргачлал, арга зүйн хувьд нэгдмэл байх шаардлагатай.
10. **Тэгш байдлыг хангах зарчим:** Хөнгөвчлөх тусламж үзүүлэгч бүх шатны байгууллага, эрүүл мэндийн мэргэжилтэн нь бүх насны, бүх өвчний оноштой өвчтөнд арьсны өнгө, хүйсийн байдал, шашин шүтлэг, хөрөнгө чинээ харгалзахгүйгээр тусламж, үйлчилгээг үзүүлнэ.

Гурав. Хөнгөвчлөх тусламж, үйлчилгээний төрөл, зонхилон үзүүлэх тусламж, үйлчилгээ

№	Хөнгөвчлөх тусламж, үйлчилгээний төрөл	Гол асуудал/ шинж тэмдэг	Зонхилон үзүүлэх тусламж, үйлчилгээ
1	Хөнгөвчлөх эмчилгээ	Өвдөлт	Өвдөлтийг үнэлэх, ДЭМБ-ын 3 шатлалт өвдөлт намдаах эмчилгээний зааврын хэрэгжилтийг хангаж ажиллах, хөнгөвчлөх эмчилгээ,
		Бусад шаналгаат шинжүүд	Үнэлэх, оношлох, эмчлэх, эмийн эмчилгээний заалт, тун тогтоох
		Хямрал, хурцадмал шинж илрэх	Өвөрмөц тусламж, үйлчилгээг үзүүлэх
2.	Хөнгөвчлөх сувилалын тусламж, үйлчилгээ	Асаргаа, сувилгаа	Асаргаа, сувилгааг мэргэжлийн түвшинд үзүүлэх, үнэлэх оношлох, төлөвлөх, хэрэгжүүлэх, мэдээлэх, үр дүнг тооцож, дахин асаргаа, сувилгааны төлөвлөгөөг

			зохиох арга хэмжээг хэрэгжүүлэх
3	Сэтгэц- нийгмийн тусламж, үйлчилгээ	Сэтгэл гутрал	Сэтгэл засал, хөдөлгөөн засал, эмийн бус эмчилгээ, зөвлөгөө олон мэргэжлийн багийн тусламжийг зохицуулах
		Шийдвэр гаргах чадвар сулрах ба хэт мэдрэг болох, айдас, бухимдал,	
		Сэтгэл хямрал /стресс/	
		Харилцах ур чадварын хямрал	Итгэл төрүүлэхүйц харилцааны ур чадвар, сэтгэлийн асуудлыг сонсох ур чадварт суурилсан тусламж үзүүлэх
		Нөхөн үржихүйн асуудал	Гэр бүлийн болон нөхөн үржихүйн асуудлаар бий болсон нөхцөл байдлыг үнэлэх, харилцан ярилцах, зөвлөх
4	Ёс зүй ухамсар, оюун санааны тусламж, үйлчилгээ	Шашин шүтлэг, соёлын асуудал	Аль болох хүсч буй орчин нөхцлийг нь бий болгох, шашин шүтлэг, соёлын зан заншилд нь хүндэтгэлтэй хандах
		Эмчилгээний ёс зүй	Тусламж, үйлчилгээг үзүүлэхдээ эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хэм, хэмжээнд тусламж, үйлчилгээг үзүүлэх
5	Нэр хүндийг хадгалах, хямралын үеийн тусламж, үйлчилгээ	Үйлчлүүлэгч бусад хүмүүсээс айх, түгших, сэтгэл хямрах	<ul style="list-style-type: none"> - Өвчний нууцыг хадгалах, - Өвчтөн болон гэр бүлийн гишүүдийн талаар таагүй мэдээ, мэдээлэл, - Өвчний тавилангийн талаар гэр бүлийн гишүүдийн зөвшөөрснөөс бусад бүлэг хүмүүст хүргэхгүй байх
6	Нийгмийн тусламж, үйлчилгээ	Гэр бүл ба орчин	Гэр бүлийн орчинд харилцан ойлголцлыг төрүүлэхүйц уур амьсгал, харилцааг бий болгох, гэр бүлийн гишүүдэд өвчний явц, тавиланг тодорхой ойлгуулах, гарч болох асуудлын үед биеэ авч явах, зан төлөвийг тодорхой түвшинд барих зөвлөмж өгөх
		Санхүүгийн асуудал	Санхүүгийн хувьд гарсан болон гарч болох хүндрэлийг гэр бүлийн гишүүдтэй хамтран ярилцах, зөвлөх, холбогдох байгууллагад асуудал тавихад нь туслах
		Хууль эрх зүйн асуудал	Гарсан хүндрэл, гарч болох эрсдлийг үйлчлүүлэгч түүний гэр бүлтэй хамтран хэлэлцэж, хууль эрхийн орчны шаардлагатай мэдээллийг өөрөө болон мэргэжлийн байгууллагад хандаж гэр бүлд өгүүлэх

7	Гэр бүлийн гишүүдийг түр зуур сэлгэн амраах тусламж үйлчилгээ	Гэр бүлийн гишүүд, ядрах ба залхах	Үйлчлүүлэгчийг асрамжилж буй гэр бүлийн гишүүдэд илэрсэн айдас, сэтгэл гутрал, нойргүйдэл, ядралт болон илэрч болох бусад эрсдлээс сэргийлж, сургалт, зөвлөгөө, гэр бүлийн гишүүдийг түр зуур сэлгэн амраах боломжийг судлан шийдвэрлэх
8	Хүнд гарз хохирол, уй гашууг тайлах тусламж, үйлчилгээ ба нас баралтыг удирдах	Уй гашуу	-Сэтгэл санааны хувьд болон бусад асуудлаар гарч болох хүндрэл, бэрхшээлийг урьдчилан ойлгуулах, сэтгэл зүйн хувьд бэлтгэлтэй байх нөхцлийг бүрдүүлэх, -Хүнд үед биеэ авч явах, зан төлөвийг тодорхой түвшинд барих зөвлөмжөөр хангах, -Өвчтөн нас барсны дараа гэр бүлийн гишүүдэд уй гашууг даван туулах сэтгэл зүйн дэмжлэг, зөвлөгөө өгөх
		Дүгнэлт, мэдээлэл, бусад анхаарах шаардлагатай асуудал	Өвчний явц, авсан арга хэмжээ, төгсгөлийг үнэн зөв бичиж дүгнэлт гаргах, холбогдох байгууллагад мэдээлэх
		Биеийг засах	Бие засах арга барил, бие засах арга барилыг гэр бүлийн гишүүдийн санал, хүсэлтийн дагуу хүндэтгэлтэй, хийж гүйцэтгэх

Дөрөв. Хөнгөвчлөх тусламж, үйлчилгээнд хамруулах шалгуур.

1. Аль нэг эрхтэн, системийн өвчлөлийн хүнд шатанд орсон, эдгэрүүлэх эмчилгээ үр дүнгүй болсон, архаг, даамжрах явцтай, тавилан муутай, амьдралын төгсгөлийн шатанд орсон, өвчтөний амьдрах хугацаа нэг жил түүнээс бага гэж тооцогдож байгаа тохиолдолд өвчтөнийг хөнгөвчлөх тусламжинд хамруулна.
2. Өвчтөнийг хөнгөвчлөх эмчилгээнд шилжүүлэх эсэхийг олон мэргэжлийн эмч, өвчтөн, түүний гэр бүлийнхэнтэй зөвлөлдөн шийдвэрлэнэ.
3. Өвчтөний амьдрах хугацаа нэг жил орчим болсныг барагцаалах шалгуурт:
 - өвчин эхэлж, даамжирсан эмгэг жам, түүх,
 - цаашдын эмчилгээнд үр дүн үзүүлэх магадлал, гарч болох эрсдэл,
 - өвчтөний амин эрхтэнүүдийн үйл ажиллагааны байдал,
 - өвчтөний биеийн ерөнхий байдал,
 - ноцтой хавсарсан эмгэг байгаа эсэх,
 - хорт хавдартай өвчтөнд Хавдар Судлалын Дорно Дахины Хамтын Ажиллагааны Бүлэг [ХСДДХАБ] –ийн үнэлгээ 3 болон,
 - Карновскийн оноо 50 юм уу түүнээс бага болсон зэрэг дээр үндэслэн шийдвэрлэнэ.

4. Өвчтөн өөрөө болон гэр бүл нь хөнгөвчлөх эмчилгээ хийлгэхийг зөвшөөрч байгаа эсэх нь хамгийн гол үндэслэл, шалгуур болно. Магадлах зорилгоор шалгуурыг давтан хийж болно.
5. Өвчтөний амьдралын үлдсэн хугацааг дараах гурван бүлгээр баримжаалан, хөнгөвчлөх тусламж, үйлчилгээний үр дүн хамгийн өндөр байх боломжийг судлан, өвчтөн түүний ар гэрийнхэний сэтгэлд нийцсэн тусламжийг үзүүлнэ. Үүнд:

5.1 Хэдэн сараас нэг жил хүртэл амьдрах тавилантай,

5.2 Хэдэн долоо хоногоос нэг сар хүртэл амьдрах тавилантай,

5.3 Хэдэн өдрөөс долоо хоног хүртэл амьдрах тавилантай буюу нас эцэслэж буй өвчтөн зэрэг болно.

Тав. Хөнгөвчлөх тусламж, үйлчилгээний хугацаа, давтамж, байгууллага,

№	Хугацаа	Тусламж, үйлчилгээ	Т/Ү-ний давтамж	Тусламж, үйлчилгээ үзүүлэгч байгууллага			
				Өрх, сум, тосгоны ЭМТ	Аймаг, дүүргийн НЭ	БОЭТ, тусгай мэргэжлийн төв	хувийн хэвшлийн байгууллага
1	Хэдэн сараас нэг жил хүртэл амьдрах тавилантай	Үндсэн эмчилгээ ба хөнгөвчлөх эмчилгээ хавсрах	1-3 сар тутам эмчилгээ, т/ү-г давтан төлөвлөх	✓	✓	✓	✓
		Эмчилгээний үр дүн, эрсдлийг тооцох		✓	✓	✓	✓
		Хөнгөвчлөх тусламж, үйлчилгээ, асаргаа сувилгаа		✓	✓	✓	✓
2	Хэдэн долоо хоногоос нэг сар хүртэл амьдрах тавилантай	Үндсэн эмчилгээ ба хөнгөвчлөх эмчилгээ хавсрах	7 хоногоос - 1 сар тутам эмчилгээ, т/ү-г давтан төлөвлөх	✓	✓	✓	✓
		Эмчилгээний үр дүнг тооцох, ба зорилгыг тогтоох		✓	✓	✓	✓
		Нотолгоонд суурилсан, өвөрмөц эмчилгээ, сувилгаа		✓	✓	✓	✓

3	Хэдэн өдрөөс долоо хоног хүртэл амьдрах тавилантай	Өвдөлт, зовиур шаналгааг эмчлэх, сувилахад гол анхаарлаа хандуулах	Өдөр тутам эмчилгээ, т/ү-г давтан төлөвлөх	v	v	v	v
4	Нас барсны дараах тусламж	Гэр бүлийнхэнд чиглэсэн тусламж	1 удаа	v	v	v	v
		Уй гашууг хуваалцах		v	v	v	v
5	Эмчилгээний үр дүнг тооцох	Мэдээлэх ба тайлагнах	Тасралтгүй явагдах	v	v	v	v

Зургаа. Хөнгөвчлөх тусламж, үйлчилгээний үнэлгээ

Эрүүл мэндийн байгууллага нь хөнгөвчлөх тусламж, үйлчилгээний чанарыг тогтмол сайжруулах үүднээс түүний суурь зарчим, арга, хэлбэрт суурилсан өвөрмөц үнэлгээг тогтмол хийнэ. Үүнд:

1. Тусламж, үйлчилгээг цаг алдалгүй үзүүлсэн байдал:

- Зөв үйлчлүүлэгчид, зөв цагт нь тусламжийг хүрч үзүүлсэн байдал,
- Хөнгөвчлөх тусламж, үйлчилгээний шуурхай байдал,
- Архаг өвчний сэдэрлээс сэргийлэх, өвчний намжмал байдал, ээнэгшлийн үеийг уртасгасан байдал.

2. Өвчтөн төвтэй тусламж, үйлчилгээ:

- Өвчтөний сэтгэл зүйн хүлээлт, хийхээр хүсч буй асуудлыг нь тодорхойлж, туслалцаа үзүүлсэн байдал,
- Тусламж, үйлчилгээ нь өвчтөн болон түүний гэр бүлийн хэрэгцээ, хүсэл сонирхолтой нийцэж буй байдал.

3. Үр дүнтэй тусламж:

- Үзүүлсэн тусламж, үйлчилгээ нь тавьсан зорилгод хүрсэн байдал,
- Тусламж, үйлчилгээний үр дүнгийн эерэг байдал.

4. Тэгш, хүртээмжтэй байдал:

- Үйлчлэх хүрээний хүн амын хамрагдалтын байдал,
- Үзүүлсэн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийн үнэлгээ,
- Үйлчлүүлэгчийн сэтгэл ханамжийн судалгааны дүн,

5. Нотолгоо, мэдлэгт суурилсан тусламж үйлчилгээ:

- Өвчтөний өөрөө, өөртөө үйлчлэх чадварыг сэргээх, архаг, хүнд өвчний өвдөлт, зовиур, шаналгааг намжаасан байдал,
- Амьдралын төгсгөлийн шатанд хөнгөвчлөх тусламж, үйлчилгээг үзүүлсэн байдал,
- Асран халамжлагч нарыг зөвлөмж, мэдээллээр хангасан байдал.